



Japan
Fund for
Poverty
Reduction



L3605/G9191 : MON48076 - ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

АЖЛЫН ДААЛГАВАР

C12 - МОНГОЛ БИЧВЭРИЙГ ДУУНД ХӨРВҮҮЛЭХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ ДОТООДЫН ЗӨВЛӨХ

А. ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай зээлийн гэрээ байгуулж (Зээлийн дугаар 3605) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах үйлчилгээг сайжруулах төсөл” (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлэхээр зөвшилцөлд хүрсэн. Тус төсөл нь Монгол Улсын Засгийн Газрыг дэмжин Улаанбаатар хот болон аймгуудын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, оролцоог дэмжиж үйлчилгээг сайжруулах зорилготой юм.

Дараах цахим хаягаас Төслийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах боломжтой:
<https://www.adb.org/sites/default/files/project-documents/48076/48076-002-rrp-en.pdf>

Төслийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь Монгол бичвэрийг дуунд хөрвүүлэхэд шаардлагатай үндсэн функцүүдийг аливаа үйлдлийн системээс үл хамааралтайгаар хэрэглэгчдэд хялбар хэрэглэх боломжтойгоор хүртээмжтэй байдлаар хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлэх зорилготой Монгол бичвэрийг дуунд хөрвүүлэх (TTS) программ хангамжийг боловсруулах зорилттой байна.

Харааны бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн API (Application Programming Interface) -д суурилсан Монгол бичвэрийг дуунд хөрвүүлэх (TTS) программ хангамжийг хөгжүүлэхийн тулд бичвэрийг дуунд хөрвүүлэх техникийн нөхцөл болоод ажлын даалгаврын төслийг тодорхойлж, боловсруулах зорилготойгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь дотоодын зөвлөлтэй хамтран ажилна.

“Азийн Хөгжлийн Банк ба түүний зээлдэгч зөвлөхийг ашиглах журам”-д заасны дагуу ХНХЯ нь зөвлөхийг шалгаруулна.

Б. ЗӨВЛӨХ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

API (Application Programming Interface)-д суурилсан нээлттэй эхийн программ хангамжийг хөгжүүлэхийн тулд бичвэрийг дуунд хөрвүүлэх техникийн нөхцөлийг тодорхойлох, Монгол бичвэрийг дуунд хөрвүүлэх зөвлөх компанийн ажлын даалгаврын төслийг боловсруулна.

Зөвлөх нь зөвлөх үйлчилгээний явцад болон үр дүнд дараах бүтээгдэхүүнийг нийлүүлэх болно. Үүнд:

1. Монгол бичвэрийг дуунд хөрвүүлэх системийг боловсруулах техникийн шаардлагад дараах үзүүлэлтийг багтаасан байна. Үүнд:

- Системийн шийдэл, модулиуд болон системийг хөгжүүлэх төлөвлөгөө;
- Системийн архитектурын шаардлага. Үүнд: тоног төхөөрөмж, хэрэглээний платформ болон технологийн шаардлагууд багтана.

2. Систем хөгжүүлэлтийн төсөв, нэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөв болон шаардлагатай дэд бүтцийн төсвийн тооцоо.

3. Бичвэрийг дуунд хөрвүүлэх системийг боловсруулах ажлын даалгавар боловсруулах, ТХН-д зөвлөхийн худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичгийг бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэн ажиллах.

4. Сургалтыг хэрэгцээг тодорхойлсон суурь судалгаа, анализ болон эцсийн хэрэглэгчдэд зориулсан сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох.

В. ТАЙЛАГНАЛЫН ШААРДЛАГА

Зөвлөх нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга болон ТХН-ийн зохицуулагчид ажлыг тайлагнана. Ажлын үйл явцыг ажлын хэсгийн уулзалт болон бусад холбогдох уулзалтын үеэр танилцуулна.

Зөвлөхийг томилсноос хойш долоо хоногийн дотор зөвлөх үйлчилгээний төлөвлөсөн үр дүнгийн ажлын төлөвлөгөөг ХНХЯ-аар батлуулна.